

11-Р АНГИЙН НИЙГЭМ СУДЛАЛ ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ
ШАЛГАЛТ-2024

ХУВИЛБАР А

1. "Капитал", "Коммунист намын тунхаг" бүтээлийг хэн бичсэн бэ?

- а. М.Вебер б. О.Райт в. Л.Уорнер г. К.Маркс

2. Газар тариаланд анжисыг нэвтрүүлсэн нь тариалангийн цар хэмжээ, үр өгөөжийг ихээр нэмэгдүүлж, түүнийг дагасан суурьшил, солилцоо, зохицуулалтуудыг бий болгосон. Энэ нь нийгмийн ямар хэв маяг вэ?

- а. Ан агнуур, түүврийн нийгэм б. Аж үйлдвэржсэний дараах нийгэм
в. газар тариалангийн нийгэм г. Аж үйлдвэржсэн нийгэм д. цэцэрлэг аж ахуйн нийгэм

3. Социализмын үеийн давхраажилтыг 4 бүтэцтэйгээр тодорхойлсон байдаг. Доорх өгөгдлөөс илүүцийг олно уу.

- а. Ажилчдын давхраа б. Номенклатурчдын давхраа
в. Малчдын давхраа г. Хөрөнгөтний давхраа д. Сэхээтний давхраа

4. Ижил буюу төстэй нөхцөлд нас, хүйс, үндэс, угсаашашин шүтлэг зэрэг шинжээр ялгаатай байдалд хүргэсэн үйлдлийг ямар алагчлал гэх вэ?

- а. шууд алагчлал б. шууд бус алагчлал
в. институтийн алагчлал г. бүлгийн алагчлал

5. Зөв харгалзуулаарай. \Судалгааны үзүүлэлтүүд\

А. Тухайн эх ологлог хийгээд түүвэр олонлог хэр зэрэг нэр төрлийн бүлгүүдээс бүрэлдэн тогтож байна вэ гэдгийг ерөнхийд нь харуулах үзүүлэлтүүд

1. голч

Б. Хамгийн их давтамжтай шинж тэмдгийн утга. Жнь: судалгаанд орлоцогчдоос хамгийн олон хүн 30 настай байсан тул насны ... нь 30 байна.

2. дундаж

В. Эх олонлог, түүвэр олонлогийг хоёр тэнцүү хэсэгт хувааж буй шинж тэмдгийн утга. Жнь: насны гол 30 гарсан болг судалгаанд оролцогчид энэ насан дээр 2 тэнцүү бүлэгт хуваагдаж байгааг илэрхийлнэ. 30-аас дээш насныхан 50%, доош насныхан 50% эзэлж байна гэсэн үг

3. Дунджийн үзүүлэлтүүд

Г. Эх олонлог түүвэр олонлогийн төв, жин дарж буй хэсэг. Жнь: судалгаанд оролцогчдын насыг давтамжаар үржүүлэн, нийт оролцогчдын тоонд хуваах замаар тооцно.

4. Моод

6. Зам харилцаа, эдийн засгийн харилцаа, мэдээлэл харилцааны хөгжлийн үндсэн дээр тусгаар соёлууд дэлхийн нэгдмэл соёлд нэгдэн нийлэх үйл явцыг юу гэдэг вэ?

- а. Соёлын даяаршил б. Соёлын аялал жуулчлал
в. соёлын дархлаа г. Соёлын адилсал

7. Түүх, соёл, урлаг, амьдралын хэв маяг, үнэт зүйл, үнэлэмж, уламжлал зэрэг соёл хоорондын харилцааны олон хэлбэрийг багтаасан өөр соёлын орчинтой биечлэн танилцахыг гэнэ.

- а. Соёлын үйлдвэрлэл б. Үндэсний соёл
в. соёлын аялал жуулчлал г. соёлын үйлчилгээ

8. ЮНЕСКО-гийн "Соёлын төрөл зүйл, соёл хоорондын харилцааг тэтгэхүй" тайлан илтгэлд хүн төрөлхтний өв үндэс болсон соёлын харилцан үйлчлэлийн ямар үндсэн гурван хэлбэр байна гэж үзсэн бэ?

- а. соёлын солилцоо, соёлыг хуулбарлан дууриах, соёлын тулгалт
б. соёлын бодлого, соёлын адилсал, соёлын тулгалт

в. соёлын солилцоо, соёлын итгэл үнэмшил, соёлын хуулбарлан дууриах

г. соёлын тулгалт, соёлын хуулбарлан дууриалт, соёлын ижилсэл

9. Кибер орон зайн онцлогоос дурьдахдаа илүүц зүйл оруулсан бол аль нь вэ?

а. хүний танин мэдэхүй, бүтээхүйн болон харилцааны бүх бололцоог илүү өргөн болгож байна

б. цэрэг арми, эдийн засаг, хил, гааль татвараас үл хамааран чөлөөт бүсийг бий болгож байна.

в. Асар богино хугацаанд мэдээлэл солилцох, танилын хүрээ өргөжиж байна

г. улс оронд суралцах, аялан жуулчлах, ажиллаж амьдарч байна.

10. Зөв харгалзуулаарай. \ соёл \

А. Соёлын эрх чөлөө 1. Хүмүүс эх хэлээрээ ярьж, хувь чанараа хөгжүүлэх, нийгмийн баталгаагаар хангагдах, өөрийн соёлыг бүтээн туурвих бололцоог эдлэх эрх

Б. Соёлын адилсал 2. Соёл өөрийн үнэт зүйлсээ хамгаалж, оршин тогтнолоо бэхжүүлэн баталгаажуулах чадвар

В. Соёлын орчин 3. Ард түмэн өөрийн соёлын хэм хэмжээ, зан үйл, хэл, үнэлэмжийн баримжааллыг ухаарч ойлгох, өөригөө ойлгох, тэрхүү соёлыг тээгч гэдгээ ухамсарлах

Г. Соёлын дархлаа 4. Соёлын үнэлэмжүүдийн харилцан нөлөөллөөр бий болж байдаг орчин

11. Засаглалын эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх хэмээн хэн ангилсан бэ?

а. Ж. Локк б. Ш. Монтескье в. Т. Парсон в.Э. Дюркгейм

12. Эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус баялагтай холбоотой маргаан, зөрчигдсэн эрх, ашиг сонирхлоо хамгаалахын тулд Иргэний шүүхэд хандаж байгаа шаардлага.

а. Өргөдөл б. Нэхэмжлэл в. санал г. Хүсэлт

13. Гэмт хэрэг үйлдсэн нэр төрд халдсан, гэрээний үүргээ биелүүлээгүй улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, аюулгүй байдалд шууд хохирол учирсан үр дагавар

а. Гэм хор б. Гэмт хэрэг в. Хор уршиг г. Хохирол

14. Захиргааны хэргийг хянан шийдвэрлэх эцсийн шийдвэрийг ямар байгууллага гаргах вэ?

а. Анхан шатны шүүх б. Давж заалдах шатны шүүх в. улсын дээд шүүх г. шүүх

15. Иргэн хүн захиргааны байгууллагатай харилцах үндсэн хэлбэрийг тоочихдоо илүүц зүйл оруулсан бол аль нь вэ?

а. өргөдөл б. нотлох барим гаргуулах шалгуулах
в. гомдол мэдүүлэх г. санал , хүсэлт гаргах

16. Зөв харгалзуулаарай.

А. Гэм хор 1. Шууд бий болох үр дагавар

Б. Хохирол 2. Хохирлын улмаас үүссэн үр дагавар

В. Хор уршиг 3. Эрүүгийн хуульд заасан гэм буруутай бүх үйлдэл, эс үйлдэл

Г. Гэмт хэрэг 4. Хохирол , хор уршиг гэдэг ойлголтыг багтаадаг. Эд хөрөнгийн буюу эд хөрөнгийн бус гэж ангилна

17. Зөв харгалзуулна уу.

А. Хүний эрхийг хамгаалах олон улсын тогтолцоо

1. 2 болон түүнээс дээш улс хуульчлан дагаж мөрдөхөөр баталсан хүний эрхийн гэрээ

Б. Тунхаглал 2. Хуульчлан дагаж мөрдөх албагүй, зөвлөмж , уриалгын шинжтэй

В. Конвенц, пакт

3. хуваасан хүний эрхийг хамгаалах бодлого

Г. Протокол

4. Хүчин төгөлдөр үйлчилж буй гэрээнд нэмэл, өөрчлөлт оруулсан баримт бичиг

18. Нийт эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор мөнгөний хэмжээ болон зээлийн хүүд нөлөөлөхийг бодлого юм.

а. Татварын б. Сангийн в. Төсвийн г. Мөнгө зээлийн д. аль нь ч биш

19. Тогтвортой хөгжлийн тулгын гурван чулуунд үл хамаарах нь аль вэ?

а. ДНБ-ын өсөлт б. Байгаль орчин в. Эдийн засаг

г. Нийгмийн байдал д. Дээрх бүгд хамаарна

20. Ирээдүй хойч үеийнхний өөрсдийн хэрэгцээгээ хангахуйц чадварыг алдагдуулахгүйгээр өнөө үеийнхний шаардлагад нийцсэн хөгжлийг юу гэж нэрлэж байгаа вэ?

а. Эдийн засгийн өсөлт б. Эдийн засгийн хөгжил

в. тогтвортой хөгжил г. Улсын хөгжил

21. Зах зээлийн тогтолцоо эдийн засгийн уналтаас өөрийгөө аварч чадахгүй гэдгийг баталж, төрийн оролцоотойгоор нийт эрэлтийг нэмэгдүүлэх замаар энэ зорилтыг шийдэх ёстой гэж үзсэн сэтгэгч аль нь вэ?

а. Ф.Хайек б. Фридман в. Ж.Кейнс г. А.Дебро д. А.Смит

22. Эдийн засгийн өсөлтийг урамшуулдаг ч инфляцийн эсрэг хүчин мөхөсддөг төрийн бодлого аль нь вэ?

а. эдийн засгийн бодлого б. хатуу бодлого в. мөнгө, зээлийн бодлого г. сангийн бодлого

23. Зөв харгалзуулна уу.

А. Төрийн ямар нэгэн оролцоогүйгээр олон улсын хооронд хийгдэх арилжаа

1. экспорт

Б. Бусад орны иргэд болон ААН-үүдээс бидний худалдан авч байгаа бараа, үйлчилгээ

2. протекционизм

В. Нэг улс бусад улс орны иргэд, ААН-үүдэд бараа, үйлчилгээ худалдах

3. Чөлөөт худалдаа

Г. Чөлөөт худалдаанд тавих хязгаарлалт

4. Импорт

24. Зөв харгалзуулна уу.

А. Нийт эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор мөнгөний хэмжээ болон зээлийн хүүд нөлөөлөх бодлого

1. Бонд

Б. Нийт эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор улсын орлого зарлагыг өөрчлөх бодлого

2. Төрийн мөнгө, зээлийн бодлого

В. Хуулийн дагуу тогтоогдсон хэмжээгээр бүх хүн, хуулийн этгээдээс төрд заавал төлөх, буцалтгүй шинжтэй хураамж юм

3. Төрийн сангийн бодлого

Г. Тодорхой хэмжээний мөнгийг тогтоосон хугацааны дараа, зохих хүүтэй эргүүлэн төлөхийн баталгаа болох үнэт цаас

4. Татвар

25. Иргэний нийгэм гэсэн ойлголт хэдий үед шинжлэх ухааны бие даасан ойлголт болсон бэ?

а. XX зууны эхэн үед б. XX зууны дунд үед

в. XXI зууны эхэн үед г. XXI зууны дунд үед

26. Нийгмийн гишүүд үг хэлэх, хэвлэн нийтлэх эрхээ эдэлж байгаа нь иргэний нийгмийг төлөвшүүлэх төрийн бодлогын аль хүрээ вэ?

а. Эдийн засгийн хүрээ б. Нийгмийн хүрээ

в. оюун санааны хүрээ г. Улс төрийн хүрээ

27. Санал хураах замаар хийж байгаа улс төрийн сонголтыггэнэ.

а. Сонгууль б. Сонгогдох эрх в. Сонгох эрх г. Суудал хуваарилах

28. Сонгогч ямар нэгэн дарамт шахалтгүйгээр гагцхүү өөрийн үзэмжээр саналаа өгөх нь сонгуулийн аль зарчим бэ?

- а. Бүх нийтээр оролцох зарчим
 в. саналыг шууд өгөх зарчим
 г. Чөлөөтэй сонгох зарчим
 д. Саналаа нууцаар гаргах зарчим
29. “2016 оны УИХ-ын ээлжит сонгуульд би зөвхөн нэр дэвшигч буюу Л.Мөнхбаатарын төлөө саналаа өгсөн” гэсэн нь сонгуулийн аль тогтолцооны тухай яригдаж байна вэ?
 а. Мажоритар тогтолцоо
 б. Пропорционал тогтолцоо
 в. Холимог тогтолцоо
 г. Харьцангуй олонхын тогтолцоо
30. Шийдвэр нь улс төрийн системийн эргэх холбооны алинд нь хамаарах вэ?
 а. Оролт
 б. Гаралт
 в. Хувиргалт
 г. Эргэх холбоо
31. Зөв харгалзуулна уу.\ улс төрийн систем\
- | | |
|-----------------------------------|---|
| А. Сонирхол илэрхийлэх | 1. Улс төрийн институтад мэдээлэл дамжуулах “суваг” |
| Б. Сонирхлыг нэгтгэх | 2. Улс төрийн нам, эвслүүд |
| В. Сонирхлыг хэрэгжүүлэх | 3. Төр |
| Г. Мэдээлэл харилцааны дэд систем | 4. Иргэний хөдөлгөөн, ТББ |
32. Зөв харгалзуулна уу.\ А. Алмондын ангилсан сонирхлын бүлгийн хэв шинж\
- | | |
|---|--|
| А. Аномик | 1. Яс үндэс, угсаа гарал, нас, хүйс зэрэг нийтлэгээрээ хамаардаг, зохион байгуулалтгүй |
| Б. Эвсэл холбооны (associational) шууд | 2. Цэрэг, зэвсэглэл, арми, сүм хийд зэрэг субъектийн удирдлага дор зохион байгуулалттай байгуулагддаг. |
| В. Эвсэл холбооны бус (non associational) | 3. Тодорхой зохион байгуулалтгүй хэсэг бөөн хүмүүсийн цугларалт, бослого, үймээн |
| Г. байгуулагдажсан (institutional) | 4. Тодорхой зорилго, чиглэлд үндэслэгдсэн зохион Байгуулалттай |
33. Монгол улс гадаад бодлогын хэдэн тулгуур чиглэлтэй вэ?
 а. 4
 б. 5
 в. 6
 г. 8
34. Монгол улс Солонгосын хойгийн аюулгүй байдлын асуудалд анхаарал тавьж хоёр Солонгостой найрсаг харилцаатай байхыг эрхэмлэдэг. Энэ нь аль бүс нутагт хамаарах вэ?
 а. Зүүн Хойд Ази
 б. Төв ба ЕвроАзи
 в. Зүүн ба Зүүн өмнөд Ази
 г. Хойд Америк
35. Монгол улсын “ гуравдагч хөрш”-ийн бодлогын суурь хэдийд тавигдсан гэж үздэг вэ?
 а. Их Монгол улсын үед
 б. Богд хаант Монгол улсын үед
 в. Ардын хувьсгалын үед
 г. 1990-ээд оны үеэс
36. Манай улстай “ Иж бүрэн түшлэл”-ийн түвшинд хүрсэн олон зуун жилийн харилцааны түүхтэй улс аль вэ?
 а. Япон
 б. БНСУ
 в. Турк
 г. Лаос
37. Улс өөрийн үндэсний ашиг сонирхол, гадаад бодлогын зорилгоо хэрэгжүүлэхдээ өөрт байгаа улс төр, стратеги, эдийн засаг, соёл зэрэг бүх арга хэрэгслээ тэнцвэртэй хоршуулах чадварыг юу гэж нэрлэдэг вэ?
 а. Зөөлөн хүч
 б. Хатуу хүч
 в. ухаалаг хүч
 г. Татах хүч
38. ОУБ-ын эрх үүргийг дурьдахдаа илүүц зүйл оруулсан бол олно уу.
 а. дипломат харилцаанд оролцож өөрийн хүрээнд хэлэлцээ хийх, олон улсын гэрээ байгуулах
 б. улс орнуудад төлөөлөгчөө суулгах, учирсан хохирлоор зарга нэхэх
 в. гэрээ байгуулсан ажиллагсдыг хөлслөх, газар нутагт нь үйл ажиллагаа эрхэлж буй улсынхаа хууль тогтоомжийн дагуу хуулийн этгээдийн эрх эдлэх
 г. Улсын дотоод хэрэгт оролцохыг цээрлэх, хууль тогтоомжийг хүндэтгэх
 д. Илүүц зүйл алга
39. Зөв харгалзуулна уу.\ Монгол улсын түншлэлийн харилцаатай улсууд\

1 Иж бүрэн стратегийн түншлэл

2 Стратегийн түншлэл

3 Иж бүрэн түншлэл

4 Өргөн хүрээтэй түншлэл

40. Зөв харгалзуулна уу.\ дипломат ажиллагаа \

1 Соёлын дипломат

ажиллагаа

а 2 улс: Канад, Австри

б 1 улс: БНХАУ

в 4 улс: БНСУ,АНУ,Герман,Турк

г 3 улс: ОХУ,Япон, Энэтхэг

а Хүнлэг байх ёс суртахууныг эрхэмлэн ямар ч үед аль ч нөхцөлд ядарч зүдэрсэн эмзэг бүлгийн хүмүүсийн эрх ашгийг дээдлэх

2 Эдийн засгийн

дипломат ажиллагаа

б Цахим сүлжээгээр дамжуулан бусдад нөлөөлөх, өөрийн орны гадаад бодлогыг сурталчилах үйл ажиллагаа

3 Хүмүүнлэгийн

дипломат ажиллагаа

в үзэл санаа, үнэт зүйл, уламжлалын солилцоон дээр үндэслэдэг үйл ажиллагаа

4 Цахим дипломат

Ажиллагаа

г Худалдаа эдийн засгийн ашиг сонирголоо дипломат аргаар хангах

ТҮЛХҮҮР НИЙГЭМ СУДЛАЛ-2024

№	Хариулт	Оноо
1	Г	2 оноо
2	В	2 оноо
3	Г	2 оноо
4	А	2 оноо
5	1В 2Г 3А 4Б	4 оноо
6	А	2 оноо
7	В	2 оноо
8	А	2 оноо
9	Г	2 оноо
10	1А 2Г 3Б 4В	4 оноо
11	Б	2 оноо
12	Б	2 оноо
13	Г	2 оноо
14	В	2 оноо
15	Б	2 оноо
16	1Б 2В 3Г 4А	4 оноо
17	1В 2Б 3А 4Г	4 оноо
18	Г	2 оноо
19	А	2 оноо
20	В	2 оноо
21	В	2 оноо
22	Г	2 оноо
23	1В 2Г 3А 4Б	4 оноо
24	1Г 2А 3Б 4В	4 оноо
25	А	2 оноо
26	В	2 оноо
27	А	2 оноо
28	Д	2 оноо
29	А	2 оноо
30	Б	2 оноо
31	1Г 2Б 3В 4А	4 оноо
32	1В 2Г 3А 4Б	4 оноо
33	В	2 оноо
34	А	2 оноо
35	Г	2 оноо
36	Б	2 оноо
37	В	2 оноо
38	Д	2 оноо
39	1Б 2Г 3В 4А	4 оноо
40	1В 2Г 3А 4Б	4 оноо
	Нийт	100 оноо